Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төв 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 7,680,694.8 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 17 арга хэмжээг улсын төсвөөс 6,087,110.3 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1,593,584.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,952,311.3 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 1,517,775.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, өмнөх оны үлдэгдлээс 228,557.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,470,210.3 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,558.0 мянган, хангамж, бараа материалын зардал 1,311.5 мянган, нормативт зардал 82,686.4 мянган, эд хогшил худалдан авах зардал 90,459.4 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 2,143.7 мянган, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,062.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	3,069,646.8	2,936,721.2	(132,925.6)	95.7
2	80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ	55.0		(55.0)	
3	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	5,163.7	5,002.0	(161.7)	96.9
4	80219	Харуул хамгаалалтын зардал	34,800.0	34,800.0	0.0	100.0
5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	28,103.9	28,103.9	0.0	100.0
6	81611	Төр хариуцах эмнэлгийн тусламж	2,881,916.0	2,881,916.0	0.0	100.0
7	83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	67,480.0	66,417.4	(1,062.6)	98.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн үйл ажиллагаагаа захиргаа, маркетингийн алба, цусны чанар, аюулгүй байдлын алба, эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба, санхүү бүртгэлийн алба, сувилахуй, үйлчилгээний 5 алба, донор зохион байгуулалтын, нэгдсэн лабораторийн, үйлдвэрлэлийн, инженер техникийн 4 бие даасан алба, тасгаас бүрдэх бөгөөд бүтцийн нэгжүүд нь өөрсдийн чиг үүргийн хүрээнд ажлаа зохион байгуулдаг байна.

3.8 Аудитын гол асуудал

Жижиг мөнгөн сангийн гүйлгээ хийхээр зөвшөөрлийн дагуу арилжааны банканд байгууллагын нэрээр картын данс нээж, өөрийн орлогыг тус банканд дахь дансаар хуримтлуулан тухайн орлогыг өдөрт нь төрийн сан дахь харилцах дансанд төвлөрүүлэхгүй, 3-15 хоногийн дараа төвлөрүүлдэг. Мөн тухайн орлогоос зарим тохиолдолд зарлагын гүйлгээ хийж байгаа нь Төрийн сангийн мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчиж байгаа тул энэхүү дансаар орлого төвлөрүүлэхгүй, орлогыг төрийн сан дахь харилцах дансанд төвлөрүүлж байх шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 275 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв 2021 онд нийт 19,159,759.1 мянган төгрөгийн 275 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 660,642.6 мянган төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид заасны дагуу ил тод байдлыг хангаж, мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулж байх, ажил үүргээ дутуу гүйцэтгэсэн ажилтанд хариуцлага тооцох, албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн төвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй гэж дүгнэлээ.

3.9.2 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 584,339.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 509,747.7 мянган төгрөгийн 10 алдааг залруулж, 74,591.9 мянган төгрөгийн зөрчлийг жилийн эцсийн аудитаар дахин хянан үзэж шийдвэрлэсэн.

Өмнөх оны аудитаар 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, жижиг мөнгөн сангийн үлдэгдэлд биет горим хэрэгжүүлэхэд 12,599.4 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнахгүй, зардалд бүртгэсэн зөрчилд өгсөн албан шаардлагын

биелэлт 80 хувь, дээд шатны байгууллагын шийдвэргүйгээр үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон, мөнгөн урамшууллыг хавтгайруулан олгосон, жижиг мөнгөн сангийн хязгаарыг баримтлаагүй 44,529.1 мянган төгрөгийн зөрчилд өгсөн албан шаардлагын биелэлт 100 хувь, 702,817.9 мянган төгрөгийн 13 зөвлөмжийн хэрэгжилт 99.2 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	57,128.5	2	57,128.5			90.0
Зөвлөмж	13	702,817.9	13	702,817.9			99,2
Нийт дүн	15	759,946.4	15	759,946.4			94,6

3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн алдаа зөрчил арилахгүй давтан гарч байгаа тул арилжааны банканд байрших картын харилцах дансны гүйлгээ, худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтийг анхаарч үзэх болно

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 91,373.0 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 9,163.3 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 2,553.9 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 78,725.8 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 930.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 6 зөрчлийн дүн 82,209.7 мянган төгрөг нь гүйцэтгэлийн шатанд тогтоосон ерөнхий материаллаг байдал хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар 9,163,3 мянган төгрөгийн зардлыг бүртгэлд тусгахдаа зардлын эдийн засгийн ангиллыг бүлэг хооронд зөрүүлж бүртгэснийг залруулав.

4.2 Төлбөрийн акт

Тайлант онд 1,202.2 мянган төгрөгөөр орлого бууруулах бичилт хийж орлогыг дутуу тайлагнасан, мөнгөн кассын үлдэгдэл 1,249.6 мянган төгрөгийг зарлагын баримт үйлдэн нягтлан бодох бүртгэлд шууд зардал болгон бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 “*Үнэн зөв байх*”, 13 дугаар зүйлийн 13.1 “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*”, 20 дугаар зүйлийн 20.2.4 “*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*” гэсэн заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Нийт 2,451.8 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх, акт тогтоов.

Илүү цагийн хөлсийг 1 дүгээр сард 60.0 мянган, 3 дугаар сард 42.1 мянган, нийт 102.1 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалт, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмыг мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон нийт 102.1 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх, акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Тайлант онд худалдан авалт, ажил үйлчилгээний 6,251,442.8 мянган төгрөгийн 55 гэрээний биелэлт, хэрэгжилтийг шалгахад бүрэн хэрэгжээгүй гэрээний төлбөр 20,129.7 мянган төгрөгөөр шилжүүлсэн, 631.1 мянган төгрөгийн гэрээг хэрэгжсэнээр тооцсон, нийт 20,760.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 “*гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “*Үнэн зөв байх*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, 20.2.6 “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан*

авагчтай тооцоо хийж, үлдээдгийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид заасны дагуу бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний биелэлтийг үнэн зөв дүгнэж, гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд гэрээнд заасан хариуцлага тооцож байх, албан шаардлага өгөв.

Өмнөх онд материал худалдан авахаар 38,063.0 мянган, үндсэн хөрөнгө бэлтгэхээр 19,902.0 мянган, нийт 57,965.0 мянган төгрөг шилжүүлснийг авлага үүсгээгүй, материал, хөрөнгийг хүлээн авахдаа үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид заасны дагуу худалдан авалтын гэрээний биелэлтийг үнэн зөв дүгнэж, тайлант хугацаанд тасалбар болголтыг зөв тооцож бүртгэл хөтөлж байх, албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дотоод аудит, дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвд ЭМЯ-аас дотоод аудит, хяналт шалгалт хийгдээгүй. Дотоод хяналт болон бүртгэлээр тавих хяналт сул байгаагаас бүртгэл тайлагналын алдаа зөрчил гарч, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил давтан гарч байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл. 19.1."Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Төсвийн тухай хуулийн 16.5.6. "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын 3.3. "Дотоод хяналт шалгалтын ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшиж мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай байна" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, бүртгэл, тайлагналтай холбоотой зөрчлийг давтан гаргахгүй байх.

Анхан шатны бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Мөнгөн кассын нярвын анхан шатны баримтыг нярвын тайлан, ерөнхий журналтай тулган шалгахад 930.0 мянган төгрөгийг ажил гүйлгээг анхан шатны баримтгүйгээр шууд зардалд бүртгэж тайлагнасан зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.7 “Мөнгөн кассын санхүүгийн баримт нь засваргүй, үнэн зөв хөтлөгдөж, баримтын бүрдлийг хангасан байх ба зарлагын төлбөр гүйцэтгэх эрхийг олгосон албан ёсны шийдвэрт үндэслэгдэн цохолт хийгдсэн байна” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жижиг мөнгөн сангийн эд хариуцагчийн тайланг хүлээн авч, хяналт хийж, бүртгэлд тусгахдаа анхан шатны үнэн зөв, иж бүрэн баримтыг үндэслэн бүртгэлд тусгах, үлдэгдлийг тоолсон тохиолдолд заавал тооцоо бодож, үлдэгдлийг баталгаажуулж, үр дүнг тайланд илэрхийлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1. Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	ЦССҮТ	АХГ-2022/375/НА-СТА-ТШЗ	Зардлыг бүртгэлд тусгахдаа зардлын эдийн засгийн ангиллыг бүлэг хооронд зөрүүлж бүртгэсэн.		1	9,163.3	1	9,163.3						
2	ЦССҮТ	АХГ-2022/375/НА-СТА-ТШЗ	Тайлант онд 1,202.2 мянган төгрөгөөр орлого бууруулах бичилт хийж орлогыг дутуу тайлагнасан, мөнгөн кассын үлдэгдэл 1,249.6 мянган төгрөгийг зарлагын баримт үйлдэн нягтлан бодох бүртгэлд шууд зардал болгон бүртгэсэн, зөрчил давтан гарсан.	Нийт 2,451.8 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх	1	2,451.8			1	2,451.8				
3	ЦССҮТ	АХГ-2022/375/НА-СТА-ТШЗ	Илүү цагийн хөлсийг 1 дүгээр сард 60.0 мянган, 3 дугаар сард 42.1 мянган, нийт 102.1 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.	Илүү тооцож олгосон нийт 102.1 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх	1	102.1			1	102.1				

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	ЦССҮТ	АХГ-2022/375/НА-СТА-ТШЗ	Тайлант онд худалдан авалт, ажил үйлчилгээний 6,251,442.8 мянган төгрөгийн 55 гэрээний биелэлт, хэрэгжилтийг шалгахад бүрэн хэрэгжээгүй гэрээний төлбөр 20,129.7 мянган төгрөгөөр шилжүүлсэн, 631.1 мянган төгрөгийн гэрээг хэрэгжсэнээр тооцсон, нийт 20,760.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн	Хууль тогтоомжид заасны дагуу бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний биелэлтийг үнэн зөв дүгнэж, гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд гэрээнд заасан хариуцлага тооцож байх	1	20,760.8					1	20,760.8		
5	ЦССҮТ	АХГ-2022/375/НА-СТА-ТШЗ	Өмнөх онд материал худалдан авахаар 38,063.0 мянган, үндсэн хөрөнгө бэлтгэхээр 19,902.0 мянган, нийт 57,965.0 мянган төгрөг шилжүүлснийг авлага үүсгээгүй, материал, хөрөнгийг хүлээн авахдаа үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэж тайлагнасан	Хууль тогтоомжид заасны дагуу худалдан авалтын гэрээний биелэлтийг үнэн зөв дүгнэж, тайлант хугацаанд тасалбар болголтыг зөв тооцож бүртгэл хөтөлж байх	1	57,965.0					1	57,965.0		
6	ЦССҮТ	АХГ-2022/375/НА-СТА-ТШЗ	ЭМЯ-с дотоод аудит хяналт хийгдээгүй. Дотоод хяналт болон бүртгэлээр тавих хяналт сул байгаагаас бүртгэл тайлагналын алдаа зөрчил гарч, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй алдаа зөрчил давтан гарч байна	Байгууллагын бүхий үйл ажиллагаанд чиг үүргийн дагуу дотоод хяналт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх	1								1	
7	ЦССҮТ	АХГ-2022/375/НА-СТА-ТШЗ	Мөнгөн кассын нярвын анхан шатны баримтыг нярвын тайлан, ерөнхий журналтай тулган шалгахад 930.0 мянган төгрөгийн анхан шатны нотлох баримтгүй зарлага гарган, шууд зардалд бүртгэж тайлагнасан	Жижиг мөнгөн сангийн эд хариуцагчийн тайланг хүлээн авч, хяналт хийж, бүртгэлд тусгахдаа анхан шатны үнэн зөв, иж бүрэн баримтыг үндэслэн бүртгэлд тусгах	1	930.0							1	930.0
			Нийт дүн		7	91,373.0	1	9,163.3	2	2,553.9	2	78,725.8	2	930.0

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2. Нийцлийн аудитын асуудлаар														
8	ЦССҮТ	АХГ-2022/375/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, шилэн дансанд байршуулах мэдээллийг тулган шалгахад зарим гүйлгээг хугацаа хоцроож оруулсан байна.	Хууль тогтоомжид заасны дагуу ил тод байдлыг хангаж, мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулж байх, ажил үүргээ дутуу гүйцэтгэсэн ажилтанд хариуцлага тооцох										
			Нийт дүн		7	91,373.0	1	9,163.3	2	2,553.9	2	78,725.8	2	930.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 31/20/50054
АХГ-2022/375/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Ажилтнуудад илүү цагийн хөлсийг 1 дүгээр сард 59,985.00 төгрөг, 3 дугаар сард 42,095.00 төгрөг, нийт 102,080.00 төгрөгийг илүү тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтууд, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох" журмыг мөрдөж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3 заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон цалин 102,080.00 (Нэг зуун хоёр мянга наян) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь Аудитын хяналт шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цус сэлбэлт судлалын төвийн захирал Н.Эрдэнэбаяр, нягтлан бодогч Б.Өнөрзул нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДАБЛЬ АКЦИОМ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Т.МЯГМАРСҮРЭН



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardлага\2022\0225_Auditin_4_Gazar-37.Docx

001090132



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 30/20150054

Улаанбаатар хот

АХГ-2022/375/МА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.

Тайлант онд 1,202,200.00 төгрөгөөр орлого бууруулах бичилт хийж, орлогыг дутуу тайлагнасан, мөнгөн кассын үлдэгдэл 1,249,627.00 төгрөгийг зарлагын баримт үйлдэн нягтлан бодох бүртгэлд шууд зардал болгон бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтууд болон УСНББОУС-1, УСНББОУС-2 мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.5, 4.2.3.5-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:


1. Орлого бууруулсан бичилт хийсэн нийт 2,451,827.00 (Хоёр сая дөрвөн зуун тавин нэгэн мянга найман зуун хорин долоон) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь Аудитын хяналт шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30 ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал Н.Эрдэнэбаяр, нягтлан бодогч Б.Өнөрзул нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДАБЛЬ АКСИОМ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА

Т.МЯГМАРСҮРЭН



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0225 Auditin 4 Газар-36.Docx

001000129



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 206/20150054

Улаанбаатар хот

АХГ-2022/375/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны худалдан авалт, ажил, үйлчилгээний гэрээний биелэлт, хэрэгжилтийг шалгахад бүрэн хэрэгжээгүй гэрээний төлбөр 20,129,690.00 мянган төгрөгийг шилжүүлсэн, 631,100.00 төгрөгийн гэрээг хэрэгжсэнээр тооцсон, нийт 20,760,790.00 төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 "гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу худалдан авалтын гэрээний биелэлтийг үнэн зөв дүгнэж, гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд гэрээнд заасан хариуцлага тооцож байх албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал Н.Эрдэнэбаяр, нягтлан бодогч Б.Өнөрзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДАБЛЬ АКСИОМ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Т.МЯГМАРСҮРЭН



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-218.Docx

0010800698



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 207/20150054

Улаанбаатар хот

АХГ-2022/375/МА-СТА-Тцз

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онд материал худалдан авахаар 38,063,000.00 төгрөг, үндсэн хөрөнгө бэлтгэхээр 19,902,000.00 төгрөг, нийт 57,965,000.00 төгрөг шилжүүлж, тайлант онд материал хөрөнгийг хүлээн авахдаа үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэж, тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтууд, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал болон УСНББОУС-1 мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.7-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хууль тогтоомжид заасны дагуу худалдан авалтын гэрээний биелэлтийг үнэн зөв дүгнэж, тайлант хугацаанд тасалбар болголтыг зөв тооцож бүртгэл хөтөлж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал Н.Эрдэнэбаяр, нягтлан бодогч Б.Өнөрзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДАБЛЬ АКСИОМ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Т.МЯГМАРСҮРЭН



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-219.Docx

0010800701



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 208/20150054
АХГ-2022/375/НА-СТА-ТшЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:


Тайлант онд шилэн дансны цахим хуудаст нийт 660,642,594.00 төгрөгийн ажил гүйлгээний 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтуудыг зөрчжээ.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу ил тод байдлыг хангаж, мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулж байх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал Н.Эрдэнэбаяр, нягтлан бодогч Б.Өнөрзул нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДАБЛЬ АКСИОМ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА

Т.МЯГМАРСҮРЭН

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.

